



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

Боловсролын салбарын бүтэц орон тоо, цалингийн сангийн төлөвлөлт, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагч нарт олгох тэтгэмжийн төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүн

**БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН
ОРОН ТООНЫ ХЯЗГААРЫГ
ХЯНАЖ, БАТЛААГҮЙ БАЙНА.**

Өлгий

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар	3
Баян-Өлгий аймгийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган	Бүлэг 1 Боловсролын салбарын орон тооны хязгаарыг хянаж, батлаагүй байна.	
Аудитын менежер Х.Женисбек	<i>Боловсролын салбарын орон тооны хязгаарыг хянаж, батлаагүй байна.</i>	6-9
Ахлах аудитор К.Риза М.Айнур	<i>Боловсролын салбарын байгууллагууд орон тоог хэтрүүлэн ажилласан байна.</i>	10-13
Аудитор Д.Назгүл Б.Үүрийнтуяа Х.Еркебулан Ж.Назгүл	<i>Сургууль, цэцэрлэгүүд харилцан адилгүй орон тоогоор ажиллаж байна.</i>	13-15
2017 оны 11 дүгээр сар	<i>Хувьсах зардлаар тооцсон цалингийн санг орон нутгийн онцлогийг харгалзан зохих хэмжээгээр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.</i>	15-16
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 94156768, 94159291 дугаарын утсаар харилцана уу	<i>Орон тоог хэтрүүлсэнээс болж 2016 онд ЕБС-ууд цалингийн сангаа 53,9 сая төгрөгөөр хэтрүүлжээ.</i>	15-16
ХАЯГ:	Бүлэг 2 Орон тоо, цалингийн сангийн төлөвлөлт, гүйцэтгэл, тэтгэмжийн олголтонд тавих дотоод хяналт хангалтгүй байна.	
Аймгийн ЗДТГазрын байр 1 дүгээр давхар 102, 106 тоот өрөө	<i>Өлгий сумын 4 дүгээр бүрэн дунд сургууль нь нэг удаагийн тэтгэмжийн мөнгийг хууль зөрчиж олгосон байна.</i>	17-18
	<i>Зарим байгууллагууд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох тэтгэмжийг хууль зөрчиж олгосон байна.</i>	18-19
	<i>Орон тоо, цалингийн сангийн төлөвлөлт, гүйцэтгэл, тэтгэмжийн олголтонд тавих хяналт хангалтгүй байна.</i>	20-21
	Дүгнэлт.....	22
	Зөвлөмж:	23
	Холбогдох байгууллагын санал:	
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал	24
	Саналд өгсөн тайлбар	25

Товчилсон үгийн тайлбар

ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
БСШУС	Боловсрол Соёл Шинжлэх Ухааны сайд
БДС	Бүрэн дунд сургууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт

ҮАГ-ын харьяа Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Боловсролын салбарын бүтэц орон тоо, цалингийн сангийн төлөвлөлт, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагч нарт олгох тэтгэмжийн төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж гарсан зөрчил, дутагдлыг арилгуулах, боловсролын салбарын төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх санал зөвлөмж боловсруулан, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Хамарсан хүрээ

Аудитад тус аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн бүх сургууль, цэцэрлэгүүдийн 2016, 2017 онуудын орон тоо, цалингийн сангийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой төсвийн хуваарь, санхүүгийн баримт материал, бусад тооцоо судалгаануудыг хамрууллаа.

Эрсдэлийн үнэлгээ

Аудитын төлөвлөлтийн явцад судалсан баримт материал, харилцан ярилцлагад тулгуурлан хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ. /Хавсралт №1/

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Аудитын Олон Улсын Стандарт (АДБОУС 300), Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журам, аудитын арга зүйг ашиглан, аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс, Боловсрол соёл урлагийн газрын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тайлбар тодруулга авах, харьцуулалт хийх, судалгаа авч дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашигласны зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Асуудлын талаар товч мэдээлэл

Тус аймгийн төрийн өмчийн 37 сургууль, 36 цэцэрлэг 2016 онд нийт 3354.5 орон тоо, 38083.6 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулжээ. Харин 2017 онд 37 сургууль, 37 цэцэрлэгт нийт 3402 орон тоо, 39524.5 сая төгрөгийн төсөв батлагдсан байна.

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Бага, дунд боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролы тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- НД-ын тухай багц хууль Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг ахлах аудитор К.Риза ахалж, ахлах аудитор М.Айнур, аудитор Д.Назгүл, Б.Үүрийнтуяа, Х.Еркебулан, Ж.Назгүл нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг төлөвлөгөө, хөтөлбөр, ажлын хуваарийн дагуу хийж, аудитын тайланг бэлтгэв.Аудитын тайлангийн хавсралт судалгаа, мэдээнүүдийг тайланд хавсаргав.

Аудит хийх явцад тус аудитын багийн аудиторууд ҮАГазрын аудитын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 8 дугаар сард Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжилт, Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүнд, 9 дүгээр сард Концессын тухай хуулиар төрийн өмчийн концессийн зүйлийн жагсаалтанд батлагдсан арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд, 10 дугаар сард Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитад тус тус хуваарилагдаж ажилласан болно.

Бүлэг 1

Боловсролын салбарын орон тооны хязгаарыг хянаж, батлаагүй байна.

Оршил

Тус аймагт төрийн өмчийн ерөнхий боловсролын 18 бүрэн дунд сургууль, 3 дунд сургууль, 16 бага сургууль бүгд 37 сургууль, сургуулийн өмнөх боловсрол олгох 37 хүүхдийн цэцэрлэг тус тус үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 14 бага сургууль, 2 дунд сургууль, 4 хүүхдийн цэцэрлэг хөдөө сумын багийн төвд үйл ажиллагаа явуулдаг байна.

Эдгээр ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгүүд нь тусгай зориулалтын шилжүүлэгээс санхүүжиж, аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамрагдаж байна.

Аудитаар ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгүүдийн орон тоо цалингийн сан, тэтгэмжийн олголт, 2016-2017 оны багш, ажилчдын хөдөлгөөн, хүүхэд, анги бүлгийн тоо, дотуур байрны хүүхдийн тооны талаарх судалгааг тухайн байгууллагуудаас авч нэгтгэн аудитад ашиглав.

1.Бүтэц орон тоо, цалингийн сангийн төлөвлөлт, зарцуулалтын талаар.

1.1.Боловсролын салбарын байгууллагуудын орон тооны төлөвлөлтийн талаар.

Боловсролын салбарын орон тооны хязгаарыг хянаж, батлаагүй байна.

Боловсролын салбарын 2016 оны төсвийг Аймгийн ИТХ-ын 2015 12 дугаар сарын 04-ний өдрийн ээлжит 16 дугаар хуралдааны 63 дугаар тогтоолоор баталж, Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит III дугаар хуралдааны 15 тогтоолоор ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгүүдийн 2016 оны төсвийг тодотгож баталсан байна.

2017 оны төсвийг Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 3 дугаар хуралдааны 12 дугаар тогтоолоор баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит IV хуралдааны 16 дугаар тогтоолоор ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгүүдийн 2017 оны төсвийг тодотгосон баталжээ.

Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д “аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 65.1.8-д “тухайн шатны төсвийн байгууллагын орон тоог төсвийн байгууллага бүрээр батлах” гэж заасан боловч ерөнхий боловсролын сургууль,

хүүхдийн цэцэрлэгүүдийн 2016, 2017 онуудын төсвийг зардлын зүйл ангиар төлөвлөж, батлуулсан боловч орон тооны хязгаарыг батлуулаагүй байна.

Санхүү, төрийн сангийн хэлтсийн боловсролын салбарын төсөв, төлөвлөгөө хариуцсан мэргэжилтний боловсруулсан 2016 оны төсвийн төсөлд төрийн өмчийн ерөнхий боловсролын 37 сургуульд 2510, 36 хүүхдийн цэцэрлэгт 844,5 нийт 3354,5 орон тоо ажиллуулахаар тооцсон байна.

Ерөнхий боловсролын сургуульд удирдах ажилтан 37, гүйцэтгэх ажилтан 1321, үйлчилгээний ажилтан 1152 байхаар, хүүхдийн цэцэрлэгт удирдах ажилтан 36, гүйцэтгэх ажилтан 410, үйлчилгээний ажилтан 398,5 байхаар тус тус тооцсон байна.

Харин 2017 онд ерөнхий боловсролын 37 сургуульд 2574, хүүхдийн 36 цэцэрлэгт 828 нийт 3402 орон тоо ажиллуулахаар тооцжээ. Ерөнхий боловсролын сургуульд удирдах ажилтан 37, гүйцэтгэх ажилтан 1595, үйлчилгээний ажилтан 768, гэрээт ажилтан 174, хүүхдийн цэцэрлэгт удирдах ажилтан 36, гүйцэтгэх 413, үйлчилгээний ажилтан 379 байхаар тус тус тооцжээ.

Орон тооны өсөлт бууралтыг 2 оноор харьцуулж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №01

	Үзүүлэлт	2016 он				2017 он				зөрүү			
		нийт орон тоо	удирдах	гүйцэтгэх	үйлчилгээ	нийт орон тоо	удирдах	гүйцэтгэх	үйлчилгээ	нийт орон тоо	удирдах	гүйцэтгэх	үйлчилгээ
1	ЕБСургууль	2510	37	1405	1068	2574	37	1595	942	64	0	190	-126
2	СӨБ	844.5	36	410	398.5	828	36	413	379	-16.5	0	3	-19.5
	Дүн	3354.5	73	1815	1466.5	3402	73	2008	1321	47.5	0	193	-145.5

Орон тоо 2017 онд 3402 болж өмнөх оноос 47.5-аар нэмэгдсэн байна. Ерөнхий боловсролын сургуулийн орон тоо 64-ээр нэмэгдэж, хүүхдийн цэцэрлэгийн орон тоо 16.5-аар хасагджээ.

Албан тушаалын ангилалаар нь үзвэл ерөнхий боловсролын сургуулийн гүйцэтгэх ажилтан 190-ээр нэмэгдэж, үйлчилгээний ажилтан 126-аар буурч, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний ажилтны орон тоо 19.5-аар хасагдаж, гүйцэтгэх ажилтны орон тоо 3-аар нэмэгджээ.

ЕБС-дад гүйцэтгэх ажилтны орон тоо нэмэгдэж байгаа шалтгааныг судалж үзэхэд сургалтын төлөвлөгөөнд орсон өөрчлөлттэй холбоотойгоор багшийн орон тоо зохих хэмжээгээр нэмэгдсэнээс гадна цалингийн сандаа багтааж гүйцэтгэх ажилтны орон тоог нэмэгдүүлсэн гэж үзэх үндэслэлтэй байна.

Сургууль, цэцэрлэгийн орон тооны өөрчлөлтийг графикаар харуулбал дараах байдалтай байна.



Орон тооны өсөлт, бууралтыг байгууллага тус бүрээр задалж авч үзвэл:

-2017 оны орон тоог өмнөх онтой харьцуулахад Өлгий сумын 1, 2, 5 дугаар бүрэн дунд сургууль, 2 дугаар бага сургууль Алтай, Буянт, Булган, Баяннуур сумын бүрэн дунд сургууль, Хөх хөтөл 9 жилийн сургуулийн орон тоо 6-13 хүнээр, Өлгий сумын 4 дүгээр бүрэн дунд сургууль, Бугат бүрэн дунд сургууль, Согог 9 жилийн сургууль, Цагаан арал, Болашах, Ховд, Улаанчулуут, Даян, Загаст нуур, Хотгор бага сургуулийн орон тоо 1-5 хүнээр тус тус нэмэгдсэн байна.

Харин Өлгий сумын 6 дугаар ахлах сургууль, 1 дүгээр бага сургууль, Дэлүүн, Улаанхус, Сагсай, Толбо сумын бүрэн дунд сургууль, Шүвтэр, Таван салаа, Тыва бага сургуулийн орон тоо өнгөрсөн оноос 1-12 хүнээр буурсан байна.

Дэлүүн, Толбо, Сагсай, Улаанхус сумын бүрэн дунд сургуулиуд 2016 оноос нэгдсэн халаалтанд шилжсэнтэй холбоотойгоор үйлчилгээний ажилтны орон тоог бууруулж төлөвлөжээ.

-Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны орон тоог өмнөх онтой харьцуулахад Өлгий сумын 8 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн байрыг 13 дугаар цэцэрлэг болгон өөрчлөн зохион байгуулж 8 дугаар цэцэрлэгийн 20 орон тоог тус цэцэрлэгт шилжүүлж, төсвийн төлөвлөгөөнд оруулжээ.

Бугат сумын хүүхдийн цэцэрлэг, Өлгий сумын Эрдэм, 9,16,18 дугаар цэцэрлэгүүдийн 2017 оны орон тоог 0,5-2 хүнээр бүгд 6,5 хүнээр нэмэгдүүлж, Дэлүүн, Сагсай, Толбо, Улаанхус, Цэнгэл сумын 1-р цэцэрлэг, Өлгий сумын 1, 3, 4, 6, 11, 15, 17 дугаар цэцэрлэгүүдийн орон тоог 1-3 хүнээр бүгд 23 хүнээр бууруулан төлөвлөсөн байна.

Албан тушаалаар нь авч үзвэл арга зүйч, дуу хөгжмийн багш, туслах багш тус бүр 1-ээр, гал тогооны туслах, сав угаагчийн орон тоо 6-гаар нэмэгдэж, нягтлан бодогч, манаач-жижүүрийн орон тоо тус бүр 0,5-аар, үйлчлэгчийн орон тоо 1,5-аар, уурын зуухны галчийн орон тоо 23-аар буурч төлөвлөгдсөн нь нэгдсэн халаалтанд шилжсэн сумдын галчийн орон тоо хасагдсантай холбоотой байна.

Төсвийн тухай хуулийн 16.5-д заасан Төсвийн шууд захирагчийн төсвийн талаар дараах бүрэн эрхийн 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, цалин хөлсийг тогтоох” гэж заасны дагуу сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчид жил бүр тухайн жилийн сургалтын төлөвлөгөө, хүүхдийн тоо, бүлгийн тоог харгалзан орон тоог шинэчилэн баталж ирсэн байна.

Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгүүдийн баталсан орон тоог Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтний төлөвлөсөн орон тооны хязгаартай харьцуулж үзэхэд дараах байдалтай байна.

	2016			2017		
	орон тооны хязгаараар	байгууллагын төлөвлөгөө	зөрүү	орон тооны хязгаараар	байгууллагын төлөвлөгөө	зөрүү
ЕБС	2510	2527	-17	2574	2597,5	-23,5
СӨБ	844.5	853,5	-9	828	856,5	-28,5
Дүн	3354.5	3380,5	-26	3402	3454	-52

Боловсролын салбарын байгууллагууд орон тооны хязгаарыг 2016 онд 26-аар, 2017 онд 52 орон тоогоор тус тус хэтрүүлэн төлөвлөсөн байна.

Санхүү, төрийн сангийн хэлтсийн боловсролын салбарын төсвийн мэргэжилтэн Ерөнхий боловсролын сургуулийн багшийн орон тоог тухайн хичээлийн жилийн сургалтын төлөвлөгөө, сурагчийн тоо, бүлгийн тоо, цэцэрлэгийн бүлгийн тоотой уялдуулан төлөвлөж, захиргаа аж ахуйн орон тоог урьд жилийн гүйцэтгэлээр тооцож ирсэн байна.

Бага, дунд боловсролын тухай хуулийн 12.10-т “Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багтаамж буюу хүүхдийн тоо, хэв шинж, ангиллыг харгалзан багшаас бусад захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг нормативыг боловсролын болон төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” гэж заасан боловч захиргаа, аж ахуйн орон тооны жишиг норм, норматив батлагдаж гараагүй байна.

Боловсролын салбарт мөрдөгдөх захиргаа, аж ахуйн орон тоог жиших норм, норматив байхгүй учир сургууль, цэцэрлэгт ажиллаж байгаа эдгээр орон тоог харьцуулж дүгнэлт хийх боломжгүй байна.

Санхүү, төрийн сангийн хэлтэс аймгийн ИТХ-аас баталсан төсвийн хязгаарт багтаан боловсролын салбарын байгууллагуудын тухайн жилийн төсвийн хуваарийг хийж батлуулж байгаа боловч орон тооны хязгаарыг батлуулаагүй, захиргаа, аж ахуйн орон тооны жишиг норм, норматив байхгүй учир салбарын хэмжээнд орон тооны төлөвлөлт үндэслэл муутай, урсгалаар хийгдэж ирсэн гэж үзэх үндэслэлтэй байна.

1.2.Боловсролын салбарын байгууллагууд батлагдсан орон тоондоо багтаан үйл ажиллагаа явуулж байгаа эсэх талаар.

Боловсролын салбарын байгууллагууд орон тоог хэтрүүлэн ажилласан байна.

Боловсролын салбарын байгууллагуудын 2016, 2017 оны орон тооны төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулж үзэхэд дараах байдалтай байна.Үүнд:

	2016			2017		
	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
ЕБС	2548	2584	-36	2585,5	2630	-44,5
СӨБ	850,5	858	-7,5	846	854	-8
Дүн	3396,5	3445	-43,5	3429,5	3489	-52,5

Дээрхи хүснэгтээс үзэхэд боловсролын байгууллагууд 2016 онд батлагдсан орон тоог 43,5-аар, 2017 оны эхний хагас жилийн байдлаар 52,5-аар тус тус хэтрүүлсэн байна.

Орон тооны хэтрэлтийг байгууллагаар нь авч үзвэл:

2016 онд Бугат, Дэлүүн, Толбо сумдын бүрэн дунд сургууль, Ёлт, Загаст нуур бага сургууль Өлгий сумын 1 дүгээр бүрэн дунд сургуулиуд баталсан орон тоог 1-3 хүнээр, Булган, Сагсай сумын бүрэн дунд сургууль, Өлгий сумын 2, 4, Баяннуур бүрэн дунд сургуулиуд баталсан орон тоог 7-10 хүнээр хэтрүүлжээ.

2017 онд Алтанцөгц, Бугат, Булган, Дэлүүн, Ногооннуур, Толбо, Улаанхус Өлгий сумын 1 дугаар бүрэн дунд сургуулиуд, Ёлт бага сургуулиуд орон тоог 1-5 хүнээр, Баяннуур, Өлгий сумын 2, 4 дүгээр бүрэн дунд сургууль батлагдсан орон тоог 10-14 хүнээр хэтрүүлсэн байна.

2016 онд Баяннуур, Алтанцөгц, Цэнгэл сумын 2,3 Буянт, Бугат сумдын хүүхдийн цэцэрлэг, Согог цэцэрлэг орон тоо 1-5 хүнээр хэтрүүлжээ.

2017 онд Эрдэм хүүхдийн цэцэрлэг, Буянт сумдын хүүхдийн цэцэрлэг, Хөх хөтөл, Согог, Өлгий сумын 13 дугаар цэцэрлэг орон тоог 1-3 хүнээр хэтрүүлэн ажилласан байна.

Сургууль, цэцэрлэгүүд харилцан адилгүй орон тоогоор ажиллаж байна.

Аудитын явцад хийсэн, нэгтгэсэн судалгааны дүнгээр ижил түвшний сургууль, цэцэрлэгүүдийг хооронд жишиж үзэхэд сургууль, цэцэрлэгүүдийн орон тоо харилцан адилгүй байгаа нь харагдаж байна. Тухайлбал:

- Цэцэрлэгүүдэд угаагчийн орон тоо 1 байхад Буянт сумын Хүүхдийн цэцэрлэг 2017 онд цагаан хэрэглэл угаагчийн 2 орон тоо ажиллуулсан.
- 2016, 2017 онд дотуур байртай Бүрэн дунд сургуулиудын нэг хүмүүжүүлэгч багшид ногдох хүүхдийн тоо дунджаар 60,1 гарч байхад Улаанхус, Цэнгэл сумын бүрэн дунд сургуулиудад 50-30 хүүхдэд 1 хүмүүжүүлэгч багш ногдож

байгаа нь дундажаас 10-30 хүүхдээр бага байгаа нь эдгээр сургуульд дотуур байрны багшийн орон тоо илүү байгааг харуулж байна.

Багийн бага сургуулиудын дотуур байрны 1 хүмүүжүүлэгч багшид 22-40 хүүхэд ногдож байна.

- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад захиргаа, аж ахуйн орон тоо харьцангуй тогтвортой боловч зарим цэцэрлэгүүд манаач-галчийн орон тоог хамтдаа гүйцэтгүүлж, зарим цэцэрлэгүүд манаач, галчийн орон тоог тус тусдаа ажиллуулсан байна.

Бага дунд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-д “Ерөнхий боловсролын сургуульд захирал, хичээлийн эрхлэгч /сургалтын менежер/, багш, нийгмийн ажилтан, бусад ажилтан ажиллана” гэж заасан боловч зарим сургуулиуд хуулинд заагаагүй хүмүүжлийн эрхлэгчийн орон тоог ажиллуулж ирсэн байна. Тухайлбал:

- 2016 онд Өлгий сумын 1, 2, 3, 4, 5, 6 дугаар бүрэн дунд сургууль, 1 дүгээр бага сургууль, Баяннуур сумын бүрэн дунд сургууль тус бүр 1 нийт 8 хүмүүжлийн эрхлэгчийн орон тоог ажиллуулсан.
- 2017 онд Баяннуур бүрэн дунд сургууль 1, Цагааннуур дунд сургуульд 1 хүмүүжлийн эрхлэгчийн орон тоо нэмэгдэж одоогоор аймгийн хэмжээнд дээрхи байгууллагуудад 10 хүмүүжлийн эрхлэгчийн орон тоог ажиллуулж байна.

Үүнээс гадна зарим байгууллагууд шаардлагагүй орон тоо бий болгох, үдийн цайг гадны байгууллагаар гэрээгэр гүйцэтгүүлж байгаа мөртлөө үдийн цайны орон тооны үйлчлэгч авч ажиллуулан цалинг төсвөөс олгож байгаа зөрчлүүд байна.

- Буянт сумын бүрэн дунд сургуульд үдийн цайг гэрээгээр гүйцэтгүүлж байгаа боловч үдийн цайны үйлчлэгчийн цалинг төсвөөс цалинжуулсан байна.
- Сагсай сумын Хүүхдийн цэцэрлэг 2017 онд бичиг хэргийн орон тоог шинээр бий болгож бусад байгууллагуудад байхгүй орон тоог авч ажиллуусан байна.
- Ногооннуур сумын бүрэн дунд сургууль нь 2017 онд аж ахуйн зохион байгуулагчийн орон тоог бий болгон ажиллуулжээ.
- Толбо ахлах сургуульд ижил түвшиний сургуулиудад сургалтын менежерийн орон тоо 4 байхад 1 сургалтын менежерийн орон тоог илүү ажиллуулсан байна.
- Өлгий сумын 4 дүгээр бүрэн дунд сургууль нь няраваас гадуур аж ахуйн эрхлэгчийн орон тоог авч ажиллуулсан байна.
- Баяннуур бүрэн дунд сургууль нь 2016 онд батлагдсан орон тоог 10 орон тоогоор хэтрүүлж, уг хэтэрсэн 10 орон тоог 2017 оны төлөвлөгөөнд оруулж баталсан мөртлөө 2017 оны батлагдсан орон тоог дахин 10-аар хэтрүүлж 2015 онд байсан орон тоог 2 жилд 20 орон тоогоор нэмэгдүүлсэн байна.

Орон тоо хэтэрсэн шалтгааныг судлаж үзэхэд аж ахуйн эрхлэгч, бичиг хэргийн эрхлэгч гэх мэт шаардлагагүй орон тоог бий болгосон, 2 нярав ажиллуулсан, үдийн цайг түрээсээр ажиллуулж байгаа боловч үдийн цайны үйлчлэгч авч ажиллуулсан, сав угаагч, хүмүүжүүлэгчийн орон тоог илүү ажиллуулсан зэргээр ижил түвшиний сургууль, цэцэрлэгүүдийг жишиж үзэхэд илүү орон тоо

ажиллуулсанаас гадна аймгийн удирдлагуудын аман шийдвэрээр илүү орон тоо бий болгож хүн авч ажиллуулсан боловч орон тоо төсвийг тодотгож өгөөгүйгээс орон тоо цалингийн сангаа хэтрүүлсэн байна.

Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн болон бүлгийн тоо нь багшийн орон тоог тогтоох үзүүлэлт болдог.

-БСШУ-ны сайд, Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 307/91/237 дугаар тушаалаар баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам”-ын 4-т “анги дүүргэлтийг бага ангид 30-35 (багийн салбар бүлэгт 20-оос доошгүй), дунд, ахлах ангид 32-35, ахлах ангийн мэргэжлийн болон сонгон судлах хичээлийн бүлэг дүүргэлтийг 25-30... байхаар зохион байгуулна” гэж заасан байна.

2015-2016, 2016-2017 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр хүүхдийн тоо, анги дүүргэлт дараах байдалтай байна.

2015-2016 оны хичээлийн жилийн анги дүүргэлт:

Байгууллагын нэр	бага		дунд		ахлах		нийт		анги дүүргэлтийн байдал		
	бүлгийн тоо	хүү/тоо	бүлгийн тоо	хүү/тоо	бүлгийн тоо	хүү тоо	бүлгийн тоо	хүү/тоо	бага	дунд	ахлах
Бүрэн дунд сургуулиуд	300	7765	201	5485	172	4482	673	17732	23.6	26.6	25.7
Багийн дунд сургуулиуд	35	536	17	335	-	-	52	871	16.1	19.9	-
Бага сургуулиуд	116	1686	-	-	-	-	116	1686	12.6		

Судалгааны дүнгээс үзэхэд 2015-2016 оны хичээлийн жилд аймгийн дундаж анги дүүргэлт бүрэн дунд сургуулиудын бага ангид 23.6, дунд ангид 26.6, ахлах ангид 25.7 хүүхэд, багийн дунд сургуулиудын бага ангид 16.1, дунд ангид 19.9, бага сургуулиудад 12.6 хүүхэд байна.

Анги дүүргэлтийг сургууль тус бүрээр авч үзэхэд Өлгий сумын 2 дугаар бүрэн дунд сургуулийн бага анги, 5 дугаар бүрэн дунд сургуулийн дунд анги, Өлгий сумын 1, 2 дугаар бага сургуулийн анги дүүргэлт нормативт түвшинд байна.

Бусад бүлгийн анги дүүргэлт нь нормативт түвшинд хүрэхгүй байгаа бөгөөд бүрэн дунд сургуулиудын хувьд анги дүүргэлт бага ангид 22.5-29.1, дунд ангид 20-31, ахлах ангид 16-30.9 хүүхэд байна.

Багийн дунд сургуулиудын анги дүүргэлт бага ангид 11.7-19.2 хүүхэд, дунд ангид 17.6-21.3 хүүхэд байна.

Болашах, Таван салаа, Даян, Улаан хад, Цэцэгт, Чихтэй, Шүвтэр бага сургуулиудад анги дүүргэлт дунджаар 5.6-8.8 хүүхэдтэй байгаа нь нормативт хэмжээний 50 хувьд ч хүрэхгүй байна. Загаст нуур, Ёлт, Тыва, Улаан чулуут, Ховд, Хотгор, Цагаан арал бага сургуулиудад анги дүүргэлт нь дунджаар 11-17.4 хүүхэдтэй байна.

2016-2017 оны хичээлийн жилийн анги дүүргэлт:

Байгууллагын нэр	бага		дунд		ахлах		нийт		анги дүүргэлтийн байдал		
	бүлгийн тоо	хүү/тоо	бүлгийн тоо	хүү/тоо	бүлгийн тоо	хүү тоо	бүлгийн тоо	хүү/тоо	бага	дунд	ахлах
Бүрэн дунд сургуулиуд	299	7650	214	5700	166	4190	679	17540	23.2	25.9	24.9
Багийн дунд сургуулиуд	31	578	18	380	-	-	49	958	18.9	20.9	-
Бага сургуулиуд	112	1659	-	-	-	-	112	1659	12.7		

2016-2017 оны хичээлийн жилд бүрэн дунд сургуулиудын анги дүүргэлтийн дундаж бага ангид 23.2, дунд ангид 25.9, ахлах ангид 24.9 хүүхэд, багийн дунд сургуулиудад бага ангид 18.9, дунд ангид 20.9 хүүхэд, бага сургуулиудад анги дүүргэлт 12.7 хүүхэд байна.

Сургууль тус бүрээр авч үзвэл:

Өлгий сумын 2, 5 дугаар бүрэн дунд сургуулийн бага анги, 5 дугаар бүрэн дунд сургууль, Ногооннуур сумын бүрэн дунд сургуулийн дунд анги, Өлгий сумын 1, 2 дугаар бага сургуулиудын бага ангийн анги дүүргэлт нормативт түвшинд байгаа ба бусад бүлгийн анги дүүргэлт нормативт түвшинд хүрээгүй байна.

Бүрэн дунд сургуулиудын анги дүүргэлтийн дундаж бага ангид 16.9-28.6 хүүхэд, дунд ангид 16.8-28.7 хүүхэд, ахлах ангид 19.8-29.3 хүүхэд байна.

Багийн дунд сургуулиудад анги дүүргэлт бага ангид 18-20.5, дунд ангид 19.4-23.7 хүүхэд байна.

Багийн бага сургуулиудад анги дүүргэлт Болашах, Даян,Тавансалаа, Улаанхад, Хотгор, Цэцэгт, Чихтэй, Шүвтэрийн сургуулиудад 4.6-9.2 хүүхэд, бусад сургуулиудад 14.8-17.6 хүүхэд байна.

Дээрхи судалгааны дүнгээс үзэхэд 1 ангид байх хүүхдийн тоо нормативт хэмжээнд хүрэхгүй ялангуяа багийн бага сургууль, хос хэл дээр сургалт явуулдаг сургуулиудад анги дүүргэлт нормативт хэмжээнээс доогуур байдаг байна.

БСШУ-ны сайдын тушаалаар 2005 онд батлагдсан “Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийн” 2.3-т бага бүлэгт 20, дунд, ахлах бүлэгт дунджаар 25 хүүхэд байхаар тусгасан ба цэцэрлэгүүдийн 2 жилийн дундаж анги дүүргэлт 25-26 хүүхэд байгаа нь дээрхи нормативыг хангаж байна.

Боловсрол, соёл, урлагийн газраас сургууль, цэцэрлэгүүдээс анги дүүргэлтийн мэдээг авч улирал бүр салбарын дүнгээр нэгтгэж, газар дээр нь танилцаж, анги дүүргэлтийг хангаж ажиллахыг анхааруулж, хяналт тавьдаг ч хөдөө сумын сургуулиудын анги дүүргэлт нормативт хэмжээнд хүрэхгүй байна.

1.3. Цалингийн сангийн төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн эсэх талаар.

Хувьсах зардлаар тооцсон цалингийн санг орон нутгийн онцлогийг харгалзан зохих хэмжээгээр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

Боловсролын салбарын цалингийн зардлыг төлөвлөхдөө өмнөх хичээлийн жилийн статистик мэдээгээр байгаа хүүхдийн тоог гол үзүүлэлт болгон ашиглаж,

Засгийн газрын 2012 оны 94, 2016 оны 242 дугаар тогтоолуудаар баталсан хувьсах зардлын нормативыг мөрдсөн байна.

Багш нарын цалин, НДШ-ийн зардал, бусад хувьсах зардал, дотуур байрны 1 суралцагчид ногдох хувьсах зардлыг дээрхи нормативаар тооцсон байна.

Харин захиргаа, аж ахуйн цалингийн талаар сургууль, цэцэрлэгүүдээс нэмэлт судалгаа авч хувьсах зардлаар тооцсон цалин дээр нэмж нийт цалингийн зардлыг төлөвлөсөн байна.

2016 оны тодотгосон төсвөөр ерөнхий боловсролын сургуулиудын үндсэн цалинг 16760,2 сая төгрөгөөр, үр дүнгийн урамшуулалт цалинг 1302,3 сая төгрөгөөр, гэрээтийн цалинг 781,1 сая төгрөгөөр нэмэгдэл цалинг 110,9 сая төгрөгөөр бүгд 18954,5 сая төгрөгөөр, цэцэрлэгүүдийн үндсэн цалинг 5130,3 сая төгрөгөөр, үр дүнгийн урамшуулалт цалинг 365,7 сая төгрөгөөр, гэрээтийн цалинг 168,6 сая төгрөгөөр бүгд 5664,6 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

2017 оны тодотгосон төсвөөр ерөнхий боловсролын сургуулиудын үндсэн цалинг 17011,2 сая төгрөгөөр, үр дүнгийн урамшуулалт цалинг 1178,3 сая төгрөгөөр, гэрээтийн цалинг 651,9 сая төгрөгөөр, нэмэгдэл цалинг 110,9 сая төгрөгөөр бүгд 18952,3 сая төгрөгөөр, цэцэрлэгүүдийн үндсэн цалинг 5207,2 сая төгрөгөөр, үр дүнгийн урамшуулалыг 334,8 сая төгрөгөөр, гэрээтийн цалинг 131,2 сая төгрөгөөр бүгд 5673,3 сая төгрөгөөр баталсан байна.

2017 оны цалингийн зардлыг өмнөх онтой харьцуулахад ерөнхий боловсролын сургуулийн цалин 2,2 сая төгрөгөөр буурч, Хүүхдийн цэцэрлэгийн цалин 8,7 сая төгрөгөөр нэмэгдэж төлөвлөгджээ.

Салбарын 2016, 2017 оны статистик мэдээнд байгаа орон тоо, хүүхдийн болон бүлгийн тоог харьцуулж үзэхэд дараах байдалтай байна.

	2016			2017			зөрүү		
	бүлгийн тоо	хүүхдийн тоо	орон тоо	бүлгийн тоо	хүүхдийн тоо	орон тоо	бүлгийн тоо	хүүхдийн тоо	орон тоо
ЕБС	841	20289	2584	840	20157	2635	-1	-132	51
СӨБ	182	4672	861	183	4794	857	1	122	-4
Дүн	1023	24961	3445	1023	24951	3492	0	-10	47

Өмнөх онтой харьцуулахад ерөнхий боловсролын сургуулийн бүлгийн тоо 1-ээр, хүүхдийн тоо 132-оор буурч, орон тоо 51-ээр өссөн байна.

Сургалтын төлөвлөгөөний дагуу зарим хичээлүүдийн цаг нэмэгдсэн, под груп нэмэгдсэн зэргээр багшийн орон тоо нэмэгдсэн гэж үзэх үндэстэй байна.

Харин сургуулийн өмнөх боловсролд бүлэг 1-ээр, хүүхдийн тоо 122-оор нэмэгдэж, орон тоо 4-өөр буурсан нь нэгдсэн халаалтанд холбогдсон сумдын хүүхдийн цэцэрлэгүүдийн галчийн орон тоо хасагдсантай холбоотой байна.

Сургууль, цэцэрлэгүүдийн гүйцэтгэх болон үйлчилгээний ажилтны харьцааг авч үзвэл 2016 онд ерөнхий боловсролын сургуулиудад гүйцэтгэх ажилтны эзлэх хувь 62/38 байснаа 2017 онд 64/36 болж 2 хувиар, сургуулийн өмнөх боловсролд

гүйцэтгэх ажилтны эзлэх хувь 2016 онд 51/49 байсан бол 2017 онд 53/47 болж 2 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Санхүү, төрийн сангийн хэлтэс төсвийн төлөвлөлт хийхдээ сургуулиудаас авсан статистик мэдээг үндэслэж байгаа боловч анги дүүргэлт /хос хэл дээр хичээллэдэг сургууль, багийн алслагдсан бага сургуулиудын анги дүүргэлт бага байгаа / бүлгийн тоотой уялдуулж гаргасан багшийн тоогоор цалингийн зардлыг төлөвлөж, захиргаа аж ахуйн цалингийн зардлыг гүйцэтгэлээр нь төлөвлөж ирсэн байна.

Үүнээс үзэхэд цалингийн санг нэг хүүхдээр тооцсон хувьсах зардлаар тооцоход ихэнхи сургуулиудад анги дүүргэлт хангалтгүй, ялангуяа хөдөөгийн багийн сургуулиуд, хос хэл дээр сургалт явуулдаг сургуулиудад анги бүлгийг нэгтгэх боломжгүй байдгаас цалингийн санг бүлгийн тоотой уялдуулан зохих хэмжээгээр нэмэгдүүлж төлөвлөдөг байна.

1.4. Цалингийн сангийн батлагдсан төсвийн зарцуулалтын талаар.

Орон тоог хэтрүүлсэнээс болж 2016 онд ЕБС-ууд цалингийн сангаа 53,9 сая төгрөгөөр хэтрүүлжээ.

Аудитад хамрагдсан байгууллагуудын 2016, 2017 оны цалингийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэгтгэж үзэхэд дараах байдалтай байна.

2016 онд ЕБС-иуд 19032,6 сая төгрөгийн, СӨБ-ын байгууллагууд 5849,9 сая төгрөгийн нийт 24882,5 сая төгрөгийн цалингийн зардлын батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулсан байна.

Цалингийн зардалд гүйцэтгэлээр ЕБС-иуд 19086,6 сая төгрөгийг зарцуулж батлагдсан төсвийг 53,9 сая төгрөгөөр хэтрүүлсэн, СӨБ-ын байгууллагууд 5833,8 сая төгрөгийг зарцуулж 16,1 сая төгрөгөөр хэмнэж нийт дүнгээр 24920,4 сая төгрөгийг зарцуулж 37,9 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлжээ.

2017 онд ЕБС-иуд 18952,3 сая төгрөгийн, СӨБ-ын байгууллагууд 5673,3 сая төгрөгийн нийт 24625,6 сая төгрөгийн цалингийн зардлын батлагдсан төсвөөр ажиллаж, эхний хагас жилийн гүйцэтгэлээр ЕБС-иуд 12343,9 сая төгрөгийг зарцуулж 65,1 хувийн гүйцэтгэлтэй, СӨБ-ын байгууллагууд 3551,7 сая төгрөгийг зарцуулж 62,6 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар цалингийн зардлын төсөв хэтрээгүй байгаа боловч 6 дугаар сард багш нарын амралтын цалин олгодогтой холбоотойгоор 7, 8 дугаар саруудын төсвийг 6 сард гүйлгэн төлөвлөснөөс тодорхой хэмжээний зөрүү гардаг байна. Үүнээс шалтгаалж боловсролын салбарын байгууллагууд жил бүр НДШ, ХХОАТ-ын өртэй гарч, оны эцэс хүртэл уг зөрүүг нөхөж, хүүхдийн тоо нэмэгдсэн зарим байгууллагуудад төсвийн тодотгол хийгддэг байна.

Гэвч сургууль, цэцэрлэгийн захиргаа, аж ахуйн орон тоог жиших норм норматив байхгүйгээс үйлчилгээний ажилтны орон тоо харилцан адилгүй, салбарын хэмжээнд орон тоо жил бүр нэмэгдэж байгаа, ерөнхий боловсролын сургуулиуд сургалтын нормтой уялдуулж багшийн орон тоог сургууль тус бүр гаргаж ажиллаж байгаа боловч аймгийн Төрийн сангаас тавих хяналт хангалтгүй

байгаа зэргээс болж салбарын цалингийн зардлын хэмжээ жил бүр нэмэгдсэн байна.

Аудитын явцад хийсэн судалгаагаар 2016 онд боловсролын байгууллагуудад 214 хүн бүр орон тоогоор ажилд орсны 6 нь шүүхийн шийдвэрээр орсон байна.

Тухайн онд өндөр насны тэтгэвэрт 65 хүн гарч, шинээр ашиглалтанд орсон Өлгий сумын 15,16,17,18 дугаар цэцэрлэгүүдэд 61 орон тоо нэмэгдсэнийг хасч тооцоход 88 хүн бүр орон тоогоор ажилд оржээ. Үүнээс гадна салбарын хэмжээнд 237 хүн түр хугацаагаар ажилласан байна.

2017 онд 89 хүн бүр орон тоогоор орсоны 5 нь шүүхийн шийдвэрээр эргэж томилогдсон байна. Тэтгэвэрт гарсан 42 хүний орон тоог нөхөж, 47 орон тоо шинээр бий болсон байна. Энэ хугацаанд 233 хүн түр хугацаагаар ажиллажээ.

Боловсролын салбарын 2016, 2017 онуудын цалингийн сангийн төлөвлөлт, гүйцэтгэлийн байдлаас дүгнэлт хийж үзэхэд сургууль, цэцэрлэгүүдийн орон тоо хэтэрч байгаа боловч цалингийн санг нэмж тодотгох, бараа үйлчилгээний бусад зардлын хэмнэлтийг цалингийн зардалд гүйлгэн зарцуулах зэргээр зохицуулалт хийж ирсэн байна.

Тухайлбал: 2016 онд ЕБС-ийн цалингийн санг 48,5 сая төгрөгөөр, СӨБ-ийн цалингийн санг 143.3 сая төгрөгөөр, 2017 оны эхний хагас жилийн байдлаар авч үзэхэд ЕБС-ийн цалингийн санг 103.5 сая төгрөгөөр, СӨБ-ийн цалингийн санг 70,6 сая төгрөгөөр тус тус нэмж тодотгосон байна.

Боловсролын салбарын 2016 оны санхүүгийн тайлангаар сургууль, цэцэрлэгүүд цалингийн сангийн батлагдсан төлөвлөгөөг нийт дүнгээр 37,9 сая төгрөгөөр хэтрүүлсэн, 2017 оны эхний 7 сарын байдлаар ихэнх байгууллагууд НДШ болон ХХОАТ-ын өглөгтэй гарч байгаа юм байна.

Бүлэг 2

Орон тоо, цалингийн сангийн төлөвлөлт, гүйцэтгэл, тэтгэмжийн олголтонд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

2.Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид олгох тэтгэмж, өндөр насны тэтгэвэрт гарсан ажилтнуудад олгож буй тусламжийн төлөвлөлт, зарцуулалтын талаар.

2.1.Боловсролын салбараас өндөр насны тэтгэвэрт гарсан багш, ажилчдад олгож буй нэг удаагийн буцалтгүй мөнгөн тэтгэмжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар.

Өлгий сумын 4 дүгээр бүрэн дунд сургууль нь нэг удаагийн тэтгэмжийн мөнгийг хууль зөрчиж олгосон байна.

Боловсролын тухай хуулийн 43.1.4-д төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, захирал, эрхлэгч, орлогч захирал, хичээлийн эрхлэгч /сургалтын менежер/, хичээлийн зохицуулагч, нийгмийн ажилтан, арга зүйч, дадлагын болон байрны багш, цэцэрлэгийн туслах багш нарт,

мөн хуулийн 43.1.5-д боловсролын сургалтын байгууллагын нягтлан бодогч, нярав, тогооч, манаач, үйлчлэгч, мужаан, цахилгаанчин, слесарь, галч болон үйлчилгээний бусад ажилтан зэрэг боловсролын туслах ажилтаны албан тушаалд 25 ба түүнээс дээш жил ажилласан иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгоход түүний үндсэн цалингаар тооцож нэг удаагийн буцалтгүй мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас нь олгох бөгөөд шаардагдах зардлыг нь тухайн жилийн төсөвт тусгана гэж заасан байна.

Нэг удаагийн тэтгэмж тооцох цалингийн дундаж хэмжээ, тэтгэмж олгох шалгуур нөхцөлийг Төрийн албаны тухай хуулийн 30.2-т заасан журмыг баримтлан Засгийн газрын 2014 оны 405 дугаар тогтоолыг мөрдөж байхаар Боловсролын тухай хуулийн 43.1.7-д заасан байна.

Боловсролын тухай хуулийн дээрхи заалтуудын дагуу тэтгэвэрт гарах багш, ажилтнуудын холбогдох материалыг үндэслэн олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийн хэмжээг тооцож тухайн байгууллагын төсөвт жил бүрийн суулгаж, санхүүжүүлж иржээ.

Өндөр насны тэтгэвэрт гарч байгаа багш, ажилтнуудад олгох нэг удаагийн тэтгэмжинд зориулан боловсролын салбарын 2016 онд тэтгэвэрт гарах 64 хүнд 818,7 сая төгрөгийн, 2015 онд тэтгэвэрт гарсан боловч тэтгэмжээ бүрэн авч чадаагүй 54 хүний тэтгэмжийн зөрүүд 504,3 сая төгрөгийн нийтдээ 1323,0 сая төгрөгийн, 2017 онд тухайн жилд тэтгэвэрт гарах 70 хүнд 923,5 сая төгрөгийн тэтгэмж олгохоор төсөвт тусгагдсан байна.

Тэтгэвэрт гарсан багш, ажилчдын тэтгэмжийг төсвийн байдлыг харгалзан тодорхой хугацаанд хувааж олгосоноос тухайн ондоо багтаан бүрэн олгож чадаагүй байна.

Тэтгэмжийг төлөвлөсөн байдлыг судалж үзэхэд жил бүрийн төсвийн төсөлд тэтгэвэрт гарах багш, ажилтнуудын боловсролын байгууллагад анх ажилд орсон тушаал, нийгмийн даатгалын дэвтэр зэрэг ажилласан хугацааг нотлох баримтуудыг эх хувиар нь тулган шалгаж хүлээж авч, сүүлийн 3 жилийн үндсэн цалингийн дунджаар тооцож тэтгэмжийн хэмжээг тогтоодог байна.

Харин салбарын хэмжээнд 25-аас доош жил ажилласан иргэнд Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу 12 сарын тэтгэмжийг олгож байна.

Салбарын хэмжээнд 2016 онд 118 багш, ажилтанд 1323,0 сая төгрөгийн тэтгэмж, 2017 оны эхний 7 сарын байдлаар 42 багш, ажилтанд 618,8 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон байна.

Аудитын явцад Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2016-2017 онд тэтгэмж олгохоор төсөвт тусгасан багш, ажилчдын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг гаргуулан авч тэтгэмжийн олголтыг сургууль, цэцэрлэгүүдийн санхүүгийн баримтаар тулгаж үзэхэд тэтгэмж авсан нэр, регистрийн дугаар зөрүүтэй байх зөрчил гараагүй ба 2017 онд Өлгий сумын 4 дүгээр бүрэн дунд сургуульд төсөвт тусгагдсан 1 хүний тэтгэмжийн мөнгийг төсөвт тусгагдаагүй өөр нэг хүнд олгосон, 1 хүнд олгох тэтгэмжийг илүү тооцож олгосон зэрэг тэтгэмжийн олголттой холбоотой зөрчлүүд илэрлээ.

Иймд Өлгий сумын 4 дүгээр бүрэн дунд сургуулийн 2017 оны батлагдсан төсөвт сургуулийн мужаан Б.Бахытад өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн 11533,8 мянган төгрөгийг өндөр насны тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж нь 2017 оны төсөвт тусгагдаагүй, тэтгэмж тооцох холбогдох баримт материалаа Төрийн санд ирүүлээгүй үйлчлэгч Х.Зизагүлд хууль бусаар олгохдоо 2018 оны төсөвт Х.Зизагүлийн өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжинд тусгагдах дүнгээс 6547,8 мянган төгрөгийг илүү олгосон байна. Мөн тус сургуульд үйлчлэгчээр ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан Т.Маринашт нэг удаагийн тэтгэмжийн мөнгийг тооцож олгоход үндэслэлгүйгээр 3316,1 мянган төгрөгийг илүү тооцож олгосон зэргээр нийтдээ 9863,9 мянган төгрөгийг хууль зөрчиж олгосныг эдгээр хүмүүсээр сургуулийн дансанд нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

2.2.Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох тэтгэмжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар.

Зарим байгууллагууд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох тэтгэмжийг хууль зөрчиж олгосон байна.

Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7-д “Дараах этгээдэд 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгох”,

- 43.1.7.а-д “сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал, хичээлийн эрхлэгч /сургалтын менежер/, сургуулийн нийгмийн

ажилтан, дотуур байрны багш, албан бус боловсролын багш, цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн номын санч, сургууль, цэцэрлэгийн эмч”,

- 43.1.7.б-д “сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгийн энэ хуулийн 43.1.7.а-д зааснаас бусад багш, туслах багш” гэж заасны дагуу 2007 оноос эхлэн жил бүр төсөвт тусган олгож эхэлсэн байна.

Сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгт тогтвор суурьшилтай ажилласан Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7-д заасан боловсролын мэргэжлийн ажилтнуудад олгох 5 жилийн тэтгэмжинд 2016 онд 146 хүнд 468,7 сая төгрөгийн, 2017 онд 711 хүнд 2404,6 сая төгрөгийн тэтгэмжийг олгохоор тухайн жилүүдийн төсөвт тусган баталсан байна.

Тэтгэмжийг төлөвлөхдөө тэтгэмжинд хамрагдах багш, ажилтнуудын сүүлийн 5 жилд ажилласан хугацааг нийгмийн даатгалын дэвтэртэй тулган баталгаажуулсан хуулбарыг авч, урьд жилүүдэд тэтгэмж авсан жагсаалттай тулгаж, өөр байгууллагаас шилжиж ирсэн хүмүүсийн өмнө ажиллаж байсан байгууллагаас нь тэтгэмжийг хэзээ олгосон талаар тодруулга авч төсвийн төсөлд тусгаж ирсэн байна.

Сургууль, цэцэрлэгүүдийн 2016-2017 оны төсвийн төсөл зохиосон баримтуудыг шалгаж үзэхэд тэтгэмж авах иргэний иргэний үнэмлэх, сүүлийн 5 жилийн нийгмийн даатгалын дэвтэрийн хуулбарыг хавсаргасан байна.

Аудитын явцад 2011-2015 онд 5 жилийн тэтгэмж олгосон жагсаалтыг сургууль, цэцэрлэгүүдээс, 2016-2017 онд тэтгэмж олгосон жагсаалтыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн мэргэжилтнээс тус тус гаргуулан авч, тухайн байгууллагуудын санхүүгийн баримттай тулган шалгаж үзэхэд дараах зөрчлүүд илэрлээ.

-Сагсай сумын Бүрэн дунд сургууль нь Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7-д заасан 5 жил тутам тэтгэмж олгох албан тушаалтаны жагсаалтанд ороогүй хичээл зохицуулагч ажилтай Б.Бейбитгүлд 3237,3 мянган төгрөгийн тэтгэмжийг, дотуур байрны багш С.Жайнагүлд багшийн үндсэн цалингаар тооцож 232,6 мянган төгрөгийн тэтгэмжийг илүү олгосоныг нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

-Өлгий сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн багш Г.Амангүлд үндсэн цалингийн шатлалыг алгасч 348,6 мянган төгрөгийн тэтгэмжийг, 16 дугаар цэцэрлэгийн багш А.Тиянахт 231,3 мянган төгрөгийн тэтгэмжийг илүү тооцож олгосныг төлүүлэхээр акт тогтоож аудитын явцад барагдууллаа.

Үүнээс гадна ажилласан хугацаа нь 5 жил хүрээгүй байхад тэтгэмж олгосон зөрчил зарим сургуулиудад гарсан байна.

-Өлгий сумын 4 дүгээр Бүрэн дунд сургууль багшаар 3 жил 2 сар ажилласан Т.Манаргүл, 4 жил 3 сар ажилласан М.Нургүл, Сагсай сумын БДС-ийн багш Аманбек, Хыдырбек, Март, Саулет, Күлдари нарт 4 жил ажиллаж хуулинд заасан хугацаа болоогүй байхад тэтгэмж олгож, Боловсролын тухай хуулийн 43.1.7 дахь заалтыг зөрчиж 4968,8 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсаныг төлүүлэхээр акт тогтоов.

Тухайн жилийн төсөвт тусгасан тэтгэмжийн мөнгийг багш нарт 5 жилийн хугацаа бүрэн болоогүй, хэдэн сар дутуу байхад олгох асуудал нийтлэг оршиж байна.

Энэ нь дараагийн тэтгэмжийг олгохдоо хугацааны зөрүү гарч болох эрсдэлтэй байгаа тул 5 жилийн хугацааг хангасан байх хуулийн шаардлагыг мөрдөж ажиллахыг зөвлөмж болгов.

Салбарын хэмжээний нэгтгэсэн судалгаагаар 2016 онд 115 багш, ажилтанд 468,7 сая төгрөгийн тэтгэмж, 2017 оны эхний 7 сарын байдлаар 467 багш, ажилтанд 1517,2 сая төгрөгийн тэтгэмжийг олгосон байна.

2.3. Орон тоо, цалингийн сан, тэтгэмжийн төлөвлөлт, гүйцэтгэлд тавьж буй дотоод хяналтын талаар.

Орон тоо, цалингийн сангийн төлөвлөлт, гүйцэтгэл, тэтгэмжийн олголтонд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д “...тусгай зориулалтын шилжүүлэг хүлээн авсан төсвийн төвлөрүүлэн захирагч нь аймаг нийслэлийн засаг дарга байна”, 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, 65 дугаар зүйлд 65.1-д “аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 65.1.8-д “тухайн шатны төсвийн байгууллагын орон тоог төсвийн байгууллага бүрээр батлах” төсвийн санхүүжилтийг бодитой тодорхойлох, төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангуулах талаар эрх хэмжээг зааж өгсөн байна.

Гэвч төсөв төвлөрүүлэн захирагчийн зүгээс харьяалагдах боловсролын байгууллагуудын 2016, 2017 онуудын орон тооны хязгаарыг тогтоож өгөөгүй, орон тоо цалингийн санд хяналт тавьж төсвийг үр ашигтай удирдах эрх үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй зэргээр боловсролын байгууллагын цалингийн сан, орон тооны төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж ирсэн байна.

Энэ нь боловсролын салбарын захирал, эрхлэгчид цалингийн сандаа багтааж байгаа гэсэн нэрийдлээр орон тоог үндэслэлгүй нэмэх, шаардлагагүй орон тоог шинээр бий болгох, харилцан адилгүй орон тоогоор үйл ажиллагаа явуулах зэргээр байгууллагын орон тоо, цалингийн сангийн төлөвлөлт, гүйцэтгэлийг хяналтгүй хэрэгжүүлэхэд нөлөөлсөн байна.

Боловсролын тухай хуулийн дагуу олгож байгаа 2 төрлийн тэтгэмжинд тухайн жилд шаардагдах хөрөнгийн хэмжээг байгууллагууд холбогдох материалыг үндэслэн төсвийн төсөлд жил бүр оруулж, үүнийг төсвийн мэргэжилтэний зүгээс хянасны эцэст тухайн жилийн төсөвт тусгах ёстой юм.

Өндөр насны тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийг нэг хүнд нэг л удаа олгодог, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласаны тэтгэмжийг 5 жилд нэг удаа олгодог тул тэтгэмжийн төлөвлөлт, олголтонд хяналт тавих бүрэн боломжтой юм.

Гэвч өндөр насны тэтгэвэрт гарсан багш, ажилчдад олгож байгаа нэг удаагийн тэтгэмжийн олголттой холбоотой төсөвт тусгагдсан 1 хүний тэтгэмжийн мөнгийг төсөвт тусгагдаагүй өөр нэг хүнд олгосон зэрэг 9863.9 мянган төгрөгийн зөрчил

илэрч акт тогтоосон ба хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа багш нарт олгох 5 жилийн тэтгэмжийн 2016 оноос өмнөх хугацааны тэтгэмж олголтын талаарх нэгдсэн судалгаа байхгүй, хуулиар тэтгэмж авах эрх үүсээгүй 1 хүнд тэтгэмж олгосон, тэтгэмж авах хугацаа болоогүй байхад тэтгэмж олгосон, албан тушаалын цалингийн шатлалыг алгассан, албан тушаалын цалинг зөрүүтэй тооцсон зэргээр тэтгэмжтэй холбоотой 9018,6 мянган төгрөгийн зөрчил илэрч акт тогтоогдлоо.

Санхүү, төрийн сангийн хэлтэс 2017 онд тэтгэмж авсан иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Ногооннуур сумын бүрэн дунд сургуулиас тэтгэвэрт гарсан 4 хүнд олгосон тэтгэмжийн зөрүүг арилгаж, 2 хүнээс илүү авсан тэтгэмжийг буцаан төлүүлж, тэтгэмжийг дутуу авсан 2 хүнд нөхөн олгож хохиролгүй болгожээ.

Тэтгэмжийн төлөвлөлт, олголтонд тавих хяналт шаардлагын хэмжээнд хүрэхгүй байгаа нь иргэдийн хүсэлтээр хийгдсэн Санхүү төрийн сангийн хэлтсийн шалгалтаар, мөн энэ удаагийн аудитын дүнгээр тогтоогдож байгаа тул цаашид тэтгэмжийн төлөвлөлт, олголтонд тавих дотоодын хяналтыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Гүйцэтгэлийн аудитын дүнгээр өндөр насны тэтгэвэрт гарсан багш, ажилчдад олгож буй нэг удаагийн буцалтгүй мөнгөн тэтгэмж болон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан багш, ажилтнуудад олгож байгаа тэтгэмжийн олголттой холбоотой нийтдээ 7 актаар **18882,5** мянган төгрөгийн төлбөрийг нөхөн төлүүлэхээр акт тогтоогдов.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас сургууль, цэцэрлэгүүдийн орон тооны хязгаарыг тогтоон хянаж, батлуулах, батлагдсан орон тоог хэтрүүлэхгүй байх, салбарын хэмжээнд харилцан адилгүй байгаа орон тоог цэгцэлж нэг мөр болгох, орон тоо болон тэтгэмжийн төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах талаар төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн сангийн хэлтсийн даргад зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч, төсвийн шууд захирагч нар болон аймгийн Төрийн сангийн төсвийн мэргэжилтэн нарт хариуцлага тооцуулахаар 2 албан шаардлага өгөгдсөн ба орон тоо хэтрүүлсэн сургууль цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгөгдөв.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Боловсролын салбарын бүтэц, орон тоог байгууллагууд цалингийн сандаа багтааж өөрсдөө тогтоож ирсэн байна.
2. Боловсролын салбарын байгууллагууд батлагдсан орон тоог жил бүр хэтрүүлж ажилласан байна.
3. Ихэнх Ерөнхий боловсролын сургуулиудад анги дүүргэлт нормативт хэмжээнд хүрээгүй байна.
4. Аймгийн Засаг дарга Боловсролын салбарын орон тооны хязгаарыг хянаж, батлаагүй байна.
5. Боловсролын салбарын цалингийн санг орон тооны гүйцэтгэлийг үндэслэн төлөвлөж ирсэн байна.
6. Төсөвт батлагдсан нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийн мөнгийг хууль бусаар өөр хүнд шилжүүлэн өгч зөрчил гаргажээ.
7. Зарим байгууллагууд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох тэтгэмжийг хууль зөрчиж олгосон байна.
8. Орон тоо, цалингийн сангийн төлөвлөлт, гүйцэтгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байна.
9. Тэтгэмжийн төлөвлөлт, олголтонд тавих дотоодын хяналт сул байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

I. Аймгийн Засаг дарга А.Гылымхан танаа:

1. Төсвийн тухай хуулийн 14.2.2, 14.2.3, 61.1, 61.3, 65.1, 65.1.8-д заасан эрх хэмжээний хүрээнд боловсролын салбарын байгууллагуудын орон тооны хязгаарыг хянаж, үндэслэлтэй тогтоож өгөх.
2. Боловсролын байгууллагуудын орон тоо, цалингийн сан, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, төсвийн хөрөнгийн үр ашиг, үр өгөөжийг дээшлүүлж, өр авлага үүсгэхгүй байх.

II. Аймгийн Санхүү Төрийн сангийн хэлтсийн дарга Х.Ербол танаа:

1. Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан багш ажилтнуудад олгосон тэтгэмжийн талаар 2011 оноос хойш иж бүрэн судалгаатай болж, жил бүр баяжуулж байх;
2. Боловсролын салбарын орон тоо, төсвийн төлөвлөлт үндэслэлтэй хийгдэж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах;

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал (Аймгийн Засаг даргаас ирүүлсэн санал)


**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
83129 Өлгий, Баян-Өлгий аймаг
Утас/факс: (976) 7042-37-62

2017.11.09 № 5-03/2019
төмөр -ны № -т

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Боловсролын салбарын бүтэц орон тоо, цалингийн сангийн төлөвлөлт, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагч нарт олгох тэтгэмжийн төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудит нь хууль журмын дагуу явагдсан байна.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  ХЕРБОЛ

ТАЙЛАНГ ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

К.РИЗА

АХЛАХ АУДИТОР

М.АЙНУР

АУДИТОР

Д.НАЗГҮЛ

АУДИТОР

Б.ҮҮРИЙНТУЯА

АУДИТОР

Х.ЕРКЕБУЛАН

АУДИТОР

Ж.НАЗГУЛ